**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2025/043/НА- СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер М.Алтантуяа<br>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор Б.Должмаа<br>Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсандамбанзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/28

танай________-ны № __________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА С.РЭНЦЭНДАГВА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 70205 (Татвар хураалт, орлого бүрдүүлэлт) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 2,432,263.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, санхүүжилтийн 99.9 хувь буюу 2,429,802.1 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 2,461.2 мянган төгрөгийг оны улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

5020212

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Баянхонгор аймгийн Татварын газар нь 2024 онд "Хариуцлагатай татвар төлөгчийн жил" зорилтыг хэрэгжүүлэхээр 5 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, оны эцэст холбогдох газруудад тайлагнасныг дүгнээгүй байна.

**Бусад асуудал**

Тус байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэж байгаа санхүүгийн программ нь үндсэн хөрөнгийн элэгдлийг сар бүр боддоггүй, 12 дугаар сард жилийн дүнгээр бодсон, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээр зарим хөрөнгө хасах тэмдэгтэй, санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай файлууд бүрэн хөрвөдөггүй зэрэг нь цаашид санхүүгийн программыг сайжруулах, хөгжүүлэлт хийх шаардлагатай байна.

Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

Хоёр: Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **90,168,983.98** | **81,069,595.62** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **13,030,000.00** | **3,590,000.00** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **13,030,000.00** | **3,590,000.00** |
| **3122** | **Гадаад валют** | **13,030,000.00** | **3,590,000.00** |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 13,030,000.00 | 3,590,000.00 |
| **33** | **АВЛАГА** | **142,426.00** | **652,229.10** |
| **335** | **Бусад авлага** | 142,426.00 | 652,229.10 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 142,426.00 | 652,229.10 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **76,996,557.98** | **76,827,366.52** |
| **354** | **Хангамжийн материал** | **76,996,557.98** | **76,827,366.52** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,241,571.00 | 7,054,561.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,665,507.46 | 16,059,566.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 418,000.00 | 418,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 534.14 | 534.14 |
| 35450 | Барилгын засварын материал | 266,500.00 | 630,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 54,404,445.38 | 52,664,205.38 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,213,210,431.86** | **2,125,013,391.78** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,213,210,431.86** | **2,125,013,391.78** |
| **392** | **Биет хөрөнгө** | **2,168,210,431.86** | **2,079,803,391.78** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,043,583,200.00 | 2,043,583,200.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -53,991,998.97 | -88,121,656.35 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 108,990,000.00 | 108,990,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -99,923,980.53 | -105,697,859.43 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 304,347,682.88 | 319,446,682.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -166,644,382.22 | -225,053,198.60 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 59,289,000.00 | 59,289,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,439,089.30 | -32,632,776.72 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,780,000.00 | 3,780,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,780,000.00 | -3,780,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **45,000,000.00** | **45,210,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 45,000,000.00 | 45,210,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,303,379,415.84** | **2,206,082,987.40** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,303,379,415.84** | **2,206,082,987.40** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,303,379,415.84** | **2,206,082,987.40** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 268,961,050.75 | 268,961,050.75 |
| 51101 | Өмч: - төрийн | 268,961,050.75 | 268,961,050.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,898,967,628.52** | **1,801,018,970.98** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,983,874,355.29 | 1,898,967,628.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -84,906,726.77 | -97,296,428.44 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 135,450,736.57 | 135,450,736.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,303,379,415.84** | **2,206,082,987.40** |

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,749,498,818.00** | **2,490,036,787.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **26,071,518.00** | **15,479,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **26,071,518.00** | **15,479,000.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 13,321,518.00 | 15,479,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 35,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,321,518.00 | 15,444,000.00 |
| 120009 | Бусад орлого | 12,750,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,723,427,300.00** | **2,474,557,787.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,717,887,300.00** | **2,432,263,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,717,887,300.00 | 2,432,263,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **5,540,000.00** | **42,294,487.50** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 5,540,000.00 | 42,294,487.50 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,834,405,544.77** | **2,587,333,215.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,834,405,544.77** | **2,587,333,215.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,742,691,642.29** | **2,411,596,379.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,259,196,304.10** | **1,801,369,076.55** |
| 210101 | Үндсэн цалин | 565,569,359.54 | 756,495,151.67 |
| 210102 | Нэмэгдэл | 321,288,515.41 | 507,134,443.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 66,594,902.56 | 91,861,975.22 |
| 210104 | Урамшуулал | 305,743,526.59 | 445,877,505.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **154,530,694.23** | **223,133,198.65** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 108,449,000.00 | 155,481,702.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,711,600.00 | 16,961,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,169,300.00 | 8,480,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,542,300.00 | 8,480,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,658,494.23 | 33,729,196.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **100,497,818.48** | **118,182,572.91** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,252,981.48 | 6,059,440.91 |
| 210302 | Түлш, халаалт | 87,355,696.00 | 104,428,192.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,889,141.00 | 7,694,940.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,610,344.30** | **20,032,656.39** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,546,550.00 | 4,911,607.91 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,025,318.94 | 7,835,901.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,604,235.36 | 2,610,672.90 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,834,240.00 | 3,474,474.58 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,320,500.00** | **10,073,567.51** |
| 210604 | Урсгал засвар | 3,320,500.00 | 10,073,567.51 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,117,200.00** | **18,262,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,117,200.00 | 18,262,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **84,894,784.35** | **107,805,078.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83,980,150.35 | 106,975,369.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 178,200.00 | 170,775.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 241,024.00 | 237,024.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 451,410.00 | 377,910.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **117,523,996.83** | **112,738,229.15** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130,580.00 | 4,607,189.07 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,301,200.00 | 4,625,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 113,092,216.83 | 103,506,040.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **91,713,902.48** | **175,736,836.78** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **73,433,976.00** | **173,275,700.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,260,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 67,423,976.00 | 0.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 170,775,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,750,000.00 | 2,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **18,279,926.48** | **2,461,136.78** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,279,926.48 | 2,461,136.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-84,906,726.77** | **-97,296,428.44** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -84,906,726.77 | **-97,296,428.44** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,736,177,300.00** | **2,474,592,787.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,750,000.00** | **35,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **12,750,000.00** | **35,000.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 0.00 | 35,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 35,000.00 |
| 120009 | Бусад орлого | 12,750,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,723,427,300.00** | **2,474,557,787.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,717,887,300.00** | **2,432,263,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,717,887,300.00 | 2,432,263,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **5,540,000.00** | **42,294,487.50** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 5,540,000.00 | 42,294,487.50 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,726,687,300.00** | **2,484,032,787.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,726,687,300.00** | **2,484,032,787.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,634,973,397.52** | **2,308,155,950.72** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,259,738,687.18** | **1,801,722,073.91** |
| 210101 | Үндсэн цалин | 556,111,743.97 | 756,495,151.67 |
| 210102 | Нэмэгдэл | 321,288,515.41 | 507,487,441.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 66,594,902.56 | 91,861,975.28 |
| 210104 | Урамшуулал | 315,743,525.24 | 445,877,505.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **154,080,736.15** | **224,021,689.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 108,049,000.00 | 156,370,193.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,711,600.00 | 16,961,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,169,300.00 | 8,480,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,542,300.00 | 8,480,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,608,536.15 | 33,729,196.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **100,497,818.48** | **118,181,572.91** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,693,590.48 | 6,058,440.91 |
| 210302 | Түлш, халаалт | 87,355,696.00 | 104,428,192.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,448,532.00 | 7,694,940.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,570,365.71** | **20,895,473.90** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,020,450.00 | 4,764,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,559,340.00 | 7,781,901.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,613,235.71 | 2,714,272.90 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,777,340.00 | 4,435,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,775,000.00** | **10,834,100.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,775,000.00 | 10,834,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,117,200.00** | **18,262,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,117,200.00 | 18,262,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **90,122,390.00** | **109,239,041.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 89,207,756.00 | 108,409,332.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 178,200.00 | 170,775.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 241,024.00 | 237,024.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 451,410.00 | 377,910.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,071,200.00** | **5,000,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,000.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,991,200.00 | 5,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **91,713,902.48** | **175,876,836.78** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **73,433,976.00** | **173,415,700.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,260,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 67,423,976.00 | 0.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 170,775,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,750,000.00 | 2,640,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **18,279,926.48** | **2,461,136.78** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,279,926.48 | 2,461,136.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,490,000.00** | **-9,440,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **9,490,000.00** | **-9,440,000.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 3,540,000.00 | 13,030,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 13,030,000.00 | 3,590,000.00 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **268,961,050.75** | **135,450,736.57** | **1,983,874,355.29** | **2,388,286,142.61** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **268,961,050.75** | **135,450,736.57** | **1,983,874,355.29** | **2,388,286,142.61** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -84,906,726.77 | -84,906,726.77 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **268,961,050.75** | **135,450,736.57** | **1,898,967,628.52** | **2,303,379,415.84** |
| D01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **268,961,050.75** | **135,450,736.57** | **1,898,967,628.52** | **2,303,379,415.84** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 268,961,050.75 | 135,450,736.57 | 1,898,967,628.52 | 2,303,379,415.84 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -97,948,657.54 | -97,296,428.44 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **268,961,050.75** | **135,450,736.57** | **1,801,018,970.98** | **2,206,082,987.40** |

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0** | **0** | **0** | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,432,263,300.00** | **2,429,802,163.22** | **2,461,136.78** | **99.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,432,263,300.00** | **2,429,802,163.22** | **2,461,136.78** | **99.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,258,847,600.00** | **2,256,386,463.22** | **2,461,136.78** | **99.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,766,114,500.00** | **1,766,114,188.41** | **311.59** | **100.0** |
| 210101 | Үндсэн цалин | 767,477,300.00 | 756,495,151.67 | 10,982,148.33 | 98.6 |
| 210102 | Нэмэгдэл | 456,243,000.00 | 471,879,555.63 | -15,636,555.63 | 103.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 85,188,100.00 | 91,861,975.28 | -6,673,875.28 | 107.8 |
| 210104 | Урамшуулал | 457,206,100.00 | 445,877,505.83 | 11,328,594.17 | 97.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **221,128,000.00** | **220,935,087.00** | **192,913.00** | **99.9** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 153,283,600.00 | 153,283,591.00 | 9.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,961,100.00 | 16,961,100.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,480,600.00 | 8,480,600.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,480,600.00 | 8,480,600.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 33,922,100.00 | 33,729,196.00 | 192,904.00 | 99.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **119,048,300.00** | **118,181,572.91** | **866,727.09** | **99.3** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,430,000.00 | 6,058,440.91 | 1,371,559.09 | 81.5 |
| 210302 | Түлш, халаалт | 103,854,000.00 | 104,428,192.00 | -574,192.00 | 100.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,764,300.00 | 7,694,940.00 | 69,360.00 | 99.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,900,000.00** | **20,860,473.90** | **1,039,526.10** | **95.3** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,900,000.00 | 4,764,300.00 | 135,700.00 | 97.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,800,000.00 | 7,781,901.00 | 18,099.00 | 99.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,600,000.00 | 2,714,272.90 | 885,727.10 | 75.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 1,200,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,400,000.00 | 4,400,000.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,960,000.00** | **10,834,100.00** | **125,900.00** | **98.9** |
| 210604 | Урсгал засвар | 10,960,000.00 | 10,834,100.00 | 125,900.00 | 98.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **18,310,000.00** | **18,262,000.00** | **48,000.00** | **99.7** |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,310,000.00 | 18,262,000.00 | 48,000.00 | 99.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **96,386,800.00** | **96,199,041.00** | **187,759.00** | **99.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 95,472,000.00 | 95,369,332.00 | 102,668.00 | 99.9 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 178,200.00 | 170,775.00 | 7,425.00 | 95.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 241,100.00 | 237,024.00 | 4,076.00 | 98.3 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 | 0.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 451,500.00 | 377,910.00 | 73,590.00 | 83.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,000,000.00** | **5,000,000.00** | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **173,415,700.00** | **173,415,700.00** | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **173,415,700.00** | **173,415,700.00** | 0.00 | 100.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 170,775,700.00 | 170,775,700.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,640,000.00 | 2,640,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,432,263,300.00** | **2,429,802,163.22** | 2,461,136.78 | 99.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,432,263,300.00** | **2,429,802,163.22** | 2,461,136.78 | 99.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,432,263,300.00 | 2,429,802,163.22 | 2,461,136.78 | 99.9 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **43.00** | **43.00** | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 39.00 | 36.00 | 3.00 | 92.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 6.00 | -3.00 | 200.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | **43.00** | **43.00** | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **43.00** | **43.00** | 0.00 | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 40.00 | 37.00 | 3.00 | 92.5 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 6.00 | -3.00 | 200.0 |

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **51,734,487.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **51,734,487.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **51,734,487.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **35,607,885.50** |
| 210102 | Нэмэгдэл | 35,607,885.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,086,602.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,086,602.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,040,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,040,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-51,734,487.50** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **13,030,000** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,590,000** |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 183,381.5 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

1. Нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлд зардлыг өглөгийн дансаар дамжуулаагүй 182,729.3 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан нь Ангилал, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй тул шууд зардлаар тайлагнасан ажил гүйлгээг өглөгийн дансаар залруулсан.
2. Байгууллагын нягтлан бодогч хүүхэд асрах болон жирэмсэн амаржсаны чөлөөтэй байгаа албан хаагчдын даатгуулагчийн төрлийг буруу мэдээлснээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 652.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь Иж бүрэн байх, Тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй тул авлагыг нэмэгдүүлэн залруулга хийсэн.

Аудитаар нийт 92,070.4 мянган төгрөгийн 5 зөрчил[1] илэрснээс 85,105.3 мянган төгрөгийн 1 зөрчлийг материаллаг бусаар, 6,965.1 мянган төгрөгийн 4 зөрчлийг материаллаг алдаагаар тооцсон ба материаллаг зөрчлөөр нийт дүн нь аудитаар бидний урьдчилан тогтоосон материаллаг дүнгээс бага тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн ба аудитаар илэрсэн 687.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 6,277.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 85,105.3 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмжийг хүргүүллээ.

**5.1. Төлбөрийн акт**

1. Байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар шилдэг татварын улсын байцаагчаар 5 албан хаагчийг шалгаруулж, тус бүр 100.0 мянган төгрөгийг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого” гэснийг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Суутган тооцоогүй хувь хүний орлогын албан татварыг байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд татварын улсын байцаагч Д.Даваасамбад 2024 оны 8 дугаар сард 637.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.1 дэх “Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэлбэрээр тооцно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид илүү олгосон цалинг байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**5.2. Албан шаардлага**

1. Баянхонгор аймгийн Татварын газрын харьяалалтай 10 ахмад настнуудыг Архангай аймгийн “Хангай ресорт” амралтын газарт амраах амралтын төлбөрт 5,000.0 мянган төгрөгийг 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр “ЖДЛ” ХХК-д шилжүүлсэн байхад холбогдох анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна: хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.4 дэх “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын харьяалалтай 10 ахмад настнуудыг амраасныг нотлох анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Хүний нөөцийн менежер, татварын улсын байцаагч М.Оюунбатыг байгууллагын даргын 2023 оны Б/23 дугаар тушаалаар нууц хамгаалах ажилтнаар томилж, албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тооцож нэмэгдэл олгохоор заасан байхад 2024 онд 30 хувиар тооцож нэмэгдэл олгосноос, тус албан хаагчид 1,277.4 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.1.8-т “Нууц хамгаалах ажилтнаар томилох тухай шийдвэрт тогтоосон журмын дагуу олгох цалингийн нэмэгдлийг тусгасан байна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид холбогдох хууль, тогтоомжийн дагуу нэмэгдлийг зөв тооцож олгон зөрчлийг арилгах

## 5.3. Зөвлөмж

Татварын Ерөнхий газраас сар бүр улс, орон нутгийн төсвийн сарын төлөвлөгөө, гүйцэтгэл үр дүнгийн шагналыг 50 хүртэл хувиар албан хаагчдад олгож байхад Баянхонгор аймгийн Татварын газрын даргын 2024.12.26-ны өдрийн А/62 дугаар тушаалаар орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсэн гэж байгууллагын 42 албан хаагчдад 85,105.3 мянган төгрөгийн нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг давхардуулан олгосон (Татварын Ерөнхий газрын даргын 2024.12.26-ны А/266 дугаар тушаалыг үндэслэн) байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2 дахь “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Сангийн сайдын 2022 оны А/282 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 2.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг зөрчсөн байна.

Зөвлөмж: Төсвийн тухай хууль, тогтоомжийн дагуу төсвийн хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлж байх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлд зардлыг өглөгийн дансаар дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасан байна. | 1 | 182,729.3 | | | 1 | 182,729.3 | 1 | 182,729.3 | | | | |
| Байгууллагын нягтлан бодогч хүүхэд асрах болон жирэмсэн амаржсаны чөлөөтэй байгаа албан хаагчдын даатгуулагчийн төрлийг буруу мэдээлснээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг илүү шилжүүлсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. | 1 | 652.2 | 1 | 652.2 | | | 1 | 652.2 | | | | |
| ДҮН | 2 | 183,381.5 | 1 | 652.2 | 1 | 182,729.3 | 2 | 183,381.5 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын даргын 2024.12.20-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар 5 албан хаагчийг шилдэг татварын улсын байцаагчийг тус бүрийг 100.0 мянган төгрөгөөр шагнаж, шагналыг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна. | 1 | 50.0 | 1 | 50.0 | | | | |
| Тайлант онд татварын улсын байцаагч Д.Даваасамбад 2024 оны 8 дугаар сард 637.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. | 1 | 637.7 | 1 | 637.7 | | | | |
| Хүний нөөцийн менежер, татварын улсын байцаагч М.Оюунбатад нууц хамгаалах ажилтны нэмэгдэлд тайлант онд 1,277.4 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 1,277.4 | | | 1 | 1277.4 | | |
| ТЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/266 дугаар тушаалаар байгууллагын даргад 3,195.8 мянга, Баянхонгор аймгийн Татварын газрын даргын мөн өдрийн А/62 дугаар тушаалаар байгууллагын 42 албан хаагчдад 85,105.3 мянга, нийт 88,301.1 мянган төгрөгийн нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг цалингийн зардлын хэмнэлт болон ТЕГ-аас оны эцэст тус зардалд хуваарилсан санхүүжилтээс олгосон байна. | 1 | 85,105.3 | | | | | 1 | 85,105.3 |
| Баянхонгор аймгийн Татварын газрын харьяалалтай 10 ахмад настнуудыг Архангай аймгийн “Хангай ресорт” амралтын газарт амраах амралтын төлбөрт 5,000.0 мянган төгрөгийг 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр “ЖДЛ” ХХК-д шилжүүлсэн байхад холбогдох анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна. | 1 | 5,000.0 | | | 1 | 5,000.0 | | |
| Дүн | 5 | 92,070.4 | 2 | 687.7 | 2 | 6,277.4 | 1 | 85,105.30 |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

---oOo---